



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хүнс, хөдөө ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/49/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: Tsoqjargalb@audit.gov.mn</p>
---	--

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 79
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ГАЛСАНДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд шинээр 4,495.3 мянган төгрөгийн авлага, 5,371.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
2. Салбарын төсвийн төслийн төлөвлөлтийн системийн үйлчилгээний төлбөрт 7,188.0 мянган төгрөгийг зарцуулсан нь сангийн яамны төсвийн төлөвлөлтийн цахим системтэй давхардсан бөгөөд төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан;

Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, мал аж ахуйг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мэргэжлийн хяналт гэсэн 4 хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс 1,094,257.4 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,090,791.8 мянган төгрөгийг зарцуулж, 3,465.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 зорилт 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 71 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 3 арга хэмжээ нь 70-аас доош хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 96.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	361,099,003.40	390,706,557.04
33	АВЛАГА	4,495,328.40	4,875,666.04
33500	Бусад авлага	4,495,328.40	4,875,666.04
33510	Байгууллагаас авах авлага	0.00	185.96
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,495,328.40	4,875,480.08
35	БАРАА МАТЕРИАЛ	356,603,675.00	385,830,891.00
35100	Түүхий эд материал	18.00	3,879,652.00
35110	Тусгай зориулалттай материал	18.00	3,879,652.00
35400	Хангамжийн материал	341,453,657.00	338,391,239.00
35410	Бичиг хэргийн материал	2,686,691.00	1,343,741.00
35440	Түлш, шатах тослох материал	1,034,973.00	400,000.00
35470	Бусад хангамжийн материал	337,731,993.00	336,647,498.00
35600	Мал амьтад	15,150,000.00	43,560,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	552,056,994.96	1,418,939,248.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	552,056,994.96	1,418,939,248.35
39200	Биет хөрөнгө	516,639,494.84	1,384,566,748.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	406,708,210.00	406,708,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(45,049,736.16)	(54,835,769.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,167,157.15	1,704,932,280.49
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(47,114,034.01)	(784,411,301.24)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	161,607,019.96	193,294,383.45
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(65,094,420.24)	(94,926,146.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,542,428.63	39,143,513.15
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(6,967,229.18)	(26,078,706.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,096,088.00	2,096,088.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(1,255,989.31)	(1,355,803.03)
39300	Биет бус хөрөнгө	35,417,500.12	34,372,500.16
39301	Програм хангамж	4,700,000.00	4,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(2,472,499.88)	(3,517,499.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,190,000.00	33,190,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	913,155,998.36	1,809,645,805.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	4,495,328.40	44,212,255.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,495,328.40	44,212,255.04
41300	Өглөг	4,495,328.40	44,212,255.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	481,250.00
41312	НДШ-ийн өглөг	0.00	481,250.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	2,020,139.00
413203	Түлш халаалтын өглөг	0.00	2,020,139.00
41360	Бусад өглөг	4,495,328.40	41,710,866.04
41361	Байгууллагад төлөх өглөг	4,495,328.40	41,710,866.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	908,660,669.96	1,765,433,550.35
51	Засгийн газрын хувь оролцоо	908,660,669.96	1,765,433,550.35
51101	-Төрийн	1,580,093,081.39	1,580,093,081.39
51200	Хуримтлагдсан үр дүн	(790,045,023.50)	66,727,856.89
51210	Өмнөх үеийн үр дүн	(758,778,583.78)	(869,348,223.50)
51220	Тайлант үеийн үр дүн	(31,266,439.72)	936,076,080.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	118,612,612.07	118,612,612.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	913,155,998.36	1,809,645,805.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,364,426.45	2,597,558,605.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	194,095,580.45	1,380,377,213.06
1200	Нийтлэг татварын бус орлого	194,095,580.45	1,380,377,213.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,100,000.00	120,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,100,000.00	120,000.00
120005	Түрээсийн орлого	0.00	2,006,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,799,428.45	1,141,818,543.46
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	168,196,152.00	236,432,669.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	824,268,846.00	1,217,181,392.00
1310	Улсын төсвөөс	776,771,900.00	1,094,257,372.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	776,771,900.00	1,094,257,372.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,496,946.00	122,924,020.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,386,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	10,031,200.00	11,683,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,813,146.00	67,691,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,652,600.00	42,163,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,011,939,142.57	1,598,308,876.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,011,939,142.57	1,598,308,876.27
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	962,791,558.24	1,485,007,081.02
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	463,633,439.12	710,431,538.52
210101	Үндсэн цалин	300,298,851.06	419,084,259.97
210102	Нэмэгдэл	124,268,545.89	222,654,578.55
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	27,624,993.24	27,058,000.00
210104	Урамшуулал	11,441,048.93	41,634,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,503,599.25	89,383,393.00
210201	Тэтгэврийн даатгал	40,125,399.25	60,744,740.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,594,400.00	7,095,718.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,675,800.00	3,800,596.51
210204	Ажилгүйдлийн даатгал	919,200.00	3,550,901.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,188,800.00	14,191,435.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,941,682.30	34,560,472.23
210301	Гэрэл, цахилгаан	1,524,960.30	1,520,285.00
210302	Түлш, халаалт	32,161,113.00	32,161,113.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,609.00	879,074.23
2104	Хангамж, бараа материалын зардал	45,267,834.00	26,401,856.00
210401	Бичиг хэрэг	4,218,150.00	3,532,700.00
210402	Тээвэр, шатахуун	29,832,738.00	12,415,893.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,806,660.00	2,023,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	391,786.00	673,500.00
210408	Бараа материал актласны зардал	8,718,500.00	7,456,463.00
2105	Нормативт зардал	69,400.00	68,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,400.00	68,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,229,700.00	14,275,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,800.00	4,075,300.00
210604	Урсгал засвар	38,203,900.00	10,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	35,919,000.00	24,070,800.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт	5,000,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	30,919,000.00	24,070,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,557,370.00	123,325,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,024,300.00	114,670,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	587,000.00	575,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,200.00	219,044.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.00	7,848,000.00
210807	Газрын төлбөр	12,870.00	12,870.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,669,533.57	462,489,807.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,973,025.73	187,309,248.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдоо	56,696,507.84	275,180,559.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,147,584.33	113,301,795.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,250,600.00	106,749,172.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	5,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	87,786,172.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,250,600.00	13,563,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,896,984.33	6,552,623.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,969,384.33	3,465,623.25
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,927,600.00	3,087,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	6,425,283.88	999,249,728.79
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	37,691,723.60	63,173,648.40
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	37,691,723.60	63,173,648.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	6,720,730.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	37,691,723.60	0.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал	0.00	56,452,917.60
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(31,266,439.72)	936,076,080.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	825,582,546.00	1,234,164,236.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	825,582,546.00	1,234,164,236.36
1310	Улсын төсвөөс	776,771,900.00	1,094,257,372.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	776,771,900.00	1,094,257,372.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,810,646.00	139,906,864.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,386,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	10,031,200.00	11,683,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	32,126,846.00	67,691,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,652,600.00	59,145,844.36
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	825,582,546.00	1,227,199,236.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825,582,546.00	1,227,199,236.36
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	776,434,961.67	1,102,653,896.75
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	463,633,439.12	710,431,538.52
210101	Үндсэн цалин	300,298,851.06	419,084,259.97
210102	Нэмэгдэл	124,268,545.89	222,654,578.55
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	27,624,993.24	27,058,000.00
210104	Урамшуулал	11,441,048.93	41,634,700.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,503,599.25	88,902,143.00
210201	Тэтгэврийн даатгал	40,125,399.25	60,263,490.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,594,400.00	7,095,718.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,675,800.00	3,800,596.51
210204	Ажилгүйдлийн даатгал	919,200.00	3,550,901.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,188,800.00	14,191,435.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,941,682.30	32,540,333.23
210301	Гэрэл, цахилгаан	1,524,960.30	1,520,285.00
210302	Түлш, халаалт	32,161,113.00	30,140,974.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,609.00	879,074.23
2104	Хангамж, бараа материалын зардал	34,019,746.00	17,368,920.00
210401	Бичиг хэрэг	2,058,800.00	2,591,200.00
210402	Тээвэр, шатахуун	29,477,386.00	11,780,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,806,660.00	2,023,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	376,900.00	673,500.00
2105	Нормативт зардал	69,400.00	68,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,400.00	68,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,229,700.00	13,260,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,800.00	3,060,300.00
210604	Урсгал засвар	38,203,900.00	10,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	36,679,000.00	24,070,800.00
210701	Гадаад албан томилолт	5,000,000.00	
210702	Дотоод албан томилолт	31,679,000.00	24,070,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,710,395.00	196,782,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,177,325.00	188,127,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	587,000.00	575,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,200.00	219,044.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.00	7,848,000.00
210807	Газрын төлбөр	12,870.00	12,870.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,648,000.00	19,228,948.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,648,000.00	19,228,948.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,147,584.33	124,545,339.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,250,600.00	106,749,172.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	5,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	87,786,172.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,250,600.00	13,563,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,896,984.33	17,796,167.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,969,384.33	3,465,623.25
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,927,600.00	14,330,544.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	0.00	6,965,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	6,965,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6,965,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	0.00	6,965,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	6,965,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	0.00	(6,965,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	(758,778,583.78)	939,927,109.68
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	(758,778,583.78)	939,927,109.68
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(31,266,439.72)	(31,266,439.72)
4	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	(790,045,023.50)	908,660,669.96
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(79,303,200.00)	(79,303,200.00)
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	(869,348,223.50)	829,357,469.96
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	936,076,080.39	936,076,080.39
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	66,727,856.89	1,765,433,550.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
12	Татварын бус орлого	1,097,662,600.00	1,090,791,748.75	6,870,851.25	99.37
12200	Тусламжийн орлого	1,097,662,600.00	1,090,791,748.75	6,870,851.25	99.37
122005	Төсвөөс санхүүжих	1,097,662,600.00	1,090,791,748.75	6,870,851.25	99.37
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,097,662,600.00	1,090,791,748.75	6,870,851.25	99.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,097,662,600.00	1,090,791,748.75	6,870,851.25	99.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	993,008,200.00	989,542,576.75	3,465,623.25	99.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,449,600.00	652,184,081.52	3,265,518.48	99.50
210101	Үндсэн цалин	427,950,600.00	419,084,259.97	8,866,340.03	97.93
210102	Нэмэгдэл	149,383,900.00	164,407,121.55	(15,023,221.55)	110.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,459,400.00	27,058,000.00	2,401,400.00	91.85
210104	Урамшуулал	48,655,700.00	41,634,700.00	7,021,000.00	85.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,631,500.00	81,631,500.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	57,316,300.00	55,322,732.24	1,993,567.76	96.52
210202	Тэтгэмжийн даатгал	6,078,800.00	6,513,244.71	(434,444.71)	107.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,039,400.00	3,509,359.51	(469,959.51)	115.46
210204	Ажилгүйдлийн даатгал	3,039,400.00	3,259,664.93	(220,264.93)	107.25
210205	Эрүүл мэндийн даатгал	12,157,600.00	13,026,498.61	(868,898.61)	107.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,543,100.00	32,540,333.23	2,766.77	99.99
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,520,285.00	(20,285.00)	101.35
210302	Түлш, халаалт	30,171,200.00	30,140,974.00	30,226.00	99.90
210303	Цэвэр, бохир ус	871,900.00	879,074.23	(7,174.23)	100.82
2104	Хангамж, бараа материалын зардал	15,863,200.00	15,863,200.00	0.00	100.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,591,200.00	2,591,200.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	10,275,200.00	10,275,200.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,023,300.00	2,023,300.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	673,500.00	673,500.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	68,100.00	68,100.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	68,100.00	68,100.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,225,300.00	20,225,300.00	0.00	100.00
210601	Багаж, техник хэрэгсэл	10,025,300.00	10,025,300.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	10,200,000.00	10,200,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	20,947,600.00	20,947,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	20,947,600.00	20,947,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	156,517,500.00	156,320,814.00	196,686.00	99.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,665,900.00	147,665,900.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	161,700.00		161,700.00	
210803	Даатгалын үйлчилгээ	575,900.00	575,000.00	900.00	99.84
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,700.00	219,044.00	11,656.00	94.95
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,848,000.00	7,848,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	35,300.00	12,870.00	22,430.00	36.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,762,300.00	9,761,648.00	652.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,762,300.00	9,761,648.00	652.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,654,400.00	101,249,172.00	3,405,228.00	96.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	5,400,000.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,191,400.00	87,786,172.00	3,405,228.00	96.27
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,063,000.00	8,063,000.00	0.00	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	27.00	27.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	0.00	100.00
8	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	139,906,864.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	139,906,864.36

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,076,320.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	58,247,457.00
210102	Нэмэгдэл	58,247,457.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,270,643.00
210201	Тэтгэврийн даатгал	4,940,758.00
210202	Тэтгэмжийн даатгал	582,474.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	291,237.00
210204	Ажилгүйдлийн даатгал	291,237.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,164,937.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,505,720.00
210402	Тээвэр, шатахуун	1,505,720.00
2107	Томилолт, зочны зардал	3,123,200.00
210702	Дотоод албан томилолт	3,123,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,462,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,462,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,467,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,467,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,830,544.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,330,544.36
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,330,544.36
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	139,906,864.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,906,864.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,906,864.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,386,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	11,683,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,691,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	59,145,844.36

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 8,971.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

- Тайлант онд дутуу төвлөрүүлсэн 2,006.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг тайланд тусгалгүй орхигдуулсныг аудитын явцад залрууллаа.
- Бараа материалын дансанд 6,965.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.2, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 22,084.7 мянган төгрөгийн зөрчил² илэрч 5 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 22,084.7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,348.7 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй үнээр борлуулсан 2,869.7 мянга, шилжиж ирсэн трактор, дагалдах тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах гэрээний дагуу төлбөрийг бүрэн барагдуулаагүйгээс 2,006.0 мянга нийт 4,875.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2 Тус байгууллага нь түлш халаалтын өглөг 2,020.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 481.3, хөнгөлөлттэй үнээр борлуулсан хүнсний ногооны үрийн өглөг 2,869.7 мянга нийт 5,371.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Аймгийн Хөдөө аж ахуйн газар болон Даталанд Технологи ХХК хооронд "Программ хангамжийн үйлчилгээний" гэрээ байгуулж Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн систем байхад салбартаа дахин систем боловсруулж, үйлчилгээний төлбөрт гэрээний дагуу 7,188.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.4 Тайлант онд аймгийн ХХААГ-ын дарга, Мөнхийн үсэг ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу "Арын сайхан хангай, зоо техникч, мал зүйчид" ном хэвлүүлэхэд 4,650.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" гэсний 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.5 Тайлант хугацаанд шилэн дансанд 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн байршуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.6 Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Б/58 дугаар захирамжаар Г.Галсандоржийг газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.3.2-т "Дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн засаг даргад хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 4,875.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.	1	4,875.6			1	4,875.6
Тус байгууллага нь 5,371.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн	1	5,371.1			1	5,371.0
Салбартаа систем боловсруулж, үйлчилгээний төлбөрт гэрээний дагуу 7,188.0 мянган төгрөгийг төлсөн	1	7,188.0			1	7,188.0
Ном хэвлүүлэхэд 4,650.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	4,650.0			1	4,650.0
Шилэн дансанд 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	0.0			1	0.0
Нийт дүн	5	22,084.7			5	22,084.7